

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... сарын ... өдөр

Төрийн ордон Улаанбаатар хот

### УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:**

1/6<sup>1</sup> дүгээр зүйл.Ус бохирдуулсны төлбөрийг ногдуулах

“6<sup>1</sup>.1.Ус бохирдуулсны төлбөрийг энэ хуулийн 4.2 заасан хугацаанаас эхлэн тооцно.

6<sup>1</sup>.2.Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Сав газрын захиргаа нь энэ хуулийн 6 дугаар зүйлд зааснаар тооцоолсон ус бохирдуулсны төлбөрийг жилээр ногдуулж, энэ хуулийн 6<sup>1</sup>.1-д заасан хугацаанаас хойш 7 хонгийн дотор татварын албанд хүргүүлнэ.

6<sup>1</sup>.3.Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ус бохирдуулсны төлбөр тооцох үзүүлэлт, төлбөрийн хувь, хэмжээ өөрчлөгдсөн тухай бүр уг өөрчлөлттэй холбогдуулан ус бохирдуулсны төлбөрийг шинэчлэн ногдуулж, 30 хоногийн дотор татварын албанд хүргүүлнэ.

6<sup>1</sup>.4.Татварын алба энэ зүйлийн 6<sup>1</sup>.2, 6<sup>1</sup>.3-д заасан ус бохирдуулсны төлбөрийн ногдуулалтын талаарх мэдээллийг төлбөр төлөгчид цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

6<sup>1</sup>.5.Татварын алба нь Татварын ерөнхий хуулийн дагуу ус бохирдуулсны төлбөрийг төсөвт төвлөрүүлж, Татварын ерөнхий хуулийн дагуу ногдуулалт, төлөлтөд хяналт тавина.

6<sup>1</sup>.6.Ус бохирдуулсны төлбөр төлөгч, төлбөр тооцох үзүүлэлт, төлбөрийн хувь хэмжээ, ногдуулалт, төлөлт болон холбогдох бусад мэдээллийг цахим, бусад хэлбэрээр харилцан солилцох журмыг ус бохирдуулсны төлбөрийн болон татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дарга хамтран батална.”

2/4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэг:

"4.7.Ус бохирдуулагч нь улирал бүр хоёроос доошгүй хаягдал усны холимог сорьц авч, өөрийн зардлаар байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариу дүнг хаягдал ус хаях, зайлуулах дүгнэлт гаргах эрх бүхий төрийн байгууллагад улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор хүргүүлнэ. "

3/6 дугаар зүйлийн 6.3- 6.11 дэх хэсэг:

"6.3.Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон сав газрын захиргаа нь бохирдуулах бодисын хэмжээ, ус бохирдуулсны төлбөрийг хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн энэ хуулийн 5.2-д заасан аргачлалын дагуу тооцож дүгнэлтийг гаргана.

6.4.Энэ хуулийн 6.3-т заасан дүгнэлтийг ажлын 10 хоногийн дотор гарган хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгох байгууллагад болон ус бохирдуулагчид хүргүүлнэ.

6.5.Хаягдал усаа цэвэрлэх байгууламжид нийлүүлдэг ус бохирдуулагчийн тухайн улиралд зайлуулж буй хаягдал усны эзлэхүүнийг бохир усны шугаман дээр суурилуулсан хэмжих хэрэгслийн заалтаар тогтооно.

6.6.Хаягдал усаа байгальд нийлүүлдэг ус бохирдуулагчийн хэмжих хэрэгслийн заалтыг сав газрын захиргааны ажилтан эсхүл тухайн сум, дүүргийн байгаль орчны хяналтын байцаагч сар бүр хянаж, баталгаажуулан акт үйлдэнэ.

6.7.Хаягдал усаа хаягдлын санд нийлүүлдэг ус бохирдуулагчийн тухайн улиралд зайлуулж буй хаягдал усны эзлэхүүнийг технологийн цэвэр усны шугаман дээр суурилуулсан хэмжих хэрэгслийн заалтаар тодорхойлсон усны эзлэхүүнээс үйлдвэр, үйлчилгээний бүтээгдэхүүнд шингэсэн усны хэмжээг хасаж тогтооно.

6.8.Бохир усны шугаман дээр суурилуулсан хэмжих хэрэгсэлгүй, эсхүл суурилуулаагүй болон хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа алдагдсан үед хаягдал усны эзлэхүүнийг технологийн цэвэр усны шугаман дээр суурилуулсан хэмжих хэрэгслийн заалтаар тодорхойлсон усны эзлэхүүнээс үйлдвэр, үйлчилгээний бүтээгдэхүүнд шингэсэн усны хэмжээг хасаж тогтооно.

6.9.Энэ хуулийн 6.7, 6.8 дахь хэсэгт заасан үйлдвэр, үйлчилгээний бүтээгдэхүүнд шингэсэн усны хэмжээг нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормыг ашиглан тооцно.

6.10.Хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг хуулийн этгээдийн ус бохирдуулсны төлбөрийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ногдуулсан төлбөртэй давхардуулан тооцохгүй.

6.11.Ус бохирдуулагч нь хаягдал усны шинжилгээ хийлгээгүй тохиолдолд хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг энэ хуулийн 5.2-т заасан аргачлалын дагуу тооцож ноогдуулна.”

4/7 дугаар зүйлийн 7.4 хэсэг:

“7.4. Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлсэн орлогоос цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд зарцуулах журмыг барилга хот байгуулалтын асуудал эрхэлсэн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

**2 дугаар зүйл.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн "үйлчилгээнд" гэсний дараа " болон байгаль орчны лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд гэж нэмсүгэй.**

**3 дугаар зүйл.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:**

1/9 дүгээр зүйлийн 9.2 дах хэсэг:

“9.2.Сав газрын захиргаа, усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төлбөрийн улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор,

жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор өссөн дүнгээр гарган татварын албанд хүргүүлнэ.”

**4 дүгээр зүйл.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн "сум, дүүргийн Засаг даргатай" гэснийг "Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай" гэж, мөн зүйлийн 4.3 дахь хэсгийн "сум, дүүргийн Засаг дарга" гэснийг "Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага" гэж, 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын "байгальд" гэснийг "байгаль орчинд" гэж тус тус өөрчилсүгэй.**

**5 дугаар зүйл.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дугаар зүйлийн 9.1. дэх хэсэг 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын "шууд" гэснийг тус тус хассугай.**

**6 дугаар зүйл.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дугаар зүйлийн 9.2.1, 9.2.1, 9.2.2 заалтыг тус тус хүчингүй болгосугай.**

**6 дугаар зүйл.Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... сарын ... өдөр

Төрийн ордон Улаанбаатар хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай **хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй.**

1/7 дугаар зүйлийн 7.3.13 дэх хэсэгт “цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээ хийх;”

2/7 дугаар зүйлийн 7.3.14 дэх хэсэгт “байгаль орчны лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн нэмэлт оруулсан хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны \_\_ сарын \_\_ өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл. Усны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй.**

1/16.4.15.ус бохирдуулсны төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу тодорхойлж ногдуулах;

2/17.1.8.ус бохирдуулсны төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу тодорхойлж ногдуулах;

**2 дугаар зүйл. Усны тухай хуулийн 16 дугаар зүйлийн “16<sup>1.4.15</sup>” гэсэн дугаарыг “16<sup>1.4.16</sup>” гэж, 17 дугаар зүйлийн “17.1.8, 17.1.9, 17.1.10, 17.1.11, 17.1.12, 17.1.13, 17.1.14,” гэсэн дугаарыг “17.1.9, 17.1.10, 17.1.11, 17.1.12, 17.1.13, 17.1.14, 17.1.15,” гэж тус тус өөрчилсүгэй.**

**3 дугаар зүйл. Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалтын “болон бохирдуулсны” гэснийг хассугай.**

**4 дүгээр зүйл. Энэ хуулийг Ус бохирдуулсны төлбөрийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР